

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/06/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Намжил Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	2
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ДАВСТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Э.БАТ-ОРШИХ ТАНАА

2022.02.25 № АУВА-2022/06/НА-СТА-ТМЗ
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200366

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,944,025.58	100,098,314.00
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	-
3121	Төгрөг	0.00	-
31211	Төрийн сангийн харилцах	0.00	-
33	АВЛАГА	44,110,039.00	24,080,000.00
335	Бусад авлага	44,110,039.00	24,080,000.00
3351	Байгууллагаас авах авлага	20,030,039.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	24,080,000.00	24,080,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	46,833,986.58	76,018,314.00
354	Хангамжийн материал	46,833,986.58	76,018,314.00
35410	Бичиг хэргийн материал	1,758,960.00	1,281,190.00
35420	Аж ахуйн материал	13,709,694.00	11,482,124.00
35430	Сэлбэг хэрэгсэл	325,440.00	250,000.00
35440	Түлш шатах тослох материал	440,147.58	-
35460	Хүнсний материал	5,770.00	-
35470	Бусад хангамжийн материал	30,593,975.00	63,005,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,191,985,065.45	2,688,431,830.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,191,985,065.45	2,688,431,830.01
392	Биет хөрөнгө	1,141,590,232.01	2,638,066,996.57
39201	Барилга, байгууламж	1,901,144,152.00	578,934,986.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,405,718,093.75)	(105,209,423.43)
39203	Авто тээврийн хэрэгсэл	174,589,800.00	213,439,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(59,642,666.54)	(112,582,666.52)
39205	Машин, тоног төхөөрөмж	376,663,664.19	367,126,707.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	(223,226,446.75)	(229,922,123.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	103,518,294.40	120,709,274.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(50,778,347.44)	(54,421,950.42)
39209	Зам гүүрийн барилга байгууламж	-	1,462,049,871.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	406,188,170.40	491,641,440.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(81,448,294.50)	(93,998,919.24)

Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39217	Номын фонд	300,000.00	300,000.00
393	Биет бус хөрөнгө	50,394,833.44	50,364,833.44
39301	Программ хангамж	1,055,000.00	1,055,000.00
39302	Хасагдуулга	(754,166.56)	(784,166.56)
39303	Бусад биет бус хөрөнгө	50,094,000.00	50,094,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,282,929,091.03	2,788,530,144.01
413	Өглөг	16,916,535.00	112,000.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	64,039.00	-
4136	Бусад өглөг	16,852,496.00	112,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	16,825,676.00	107,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	26,820.00	5,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,266,012,556.03	2,788,418,144.01
51	Засгийн газрын хувь оролцоо	1,266,012,556.03	2,788,418,144.01
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,230,472,840.41	1,230,472,840.41
51101	Өмч: -Төрийн өмч	1,230,472,840.41	1,230,472,840.41
512	Хуримтлагдсан үр дүн	(480,069,366.66)	1,042,860,013.68
	Өмнөх үеийн үр дүн	(480,069,366.66)	(479,545,574.30)
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,522,405,587.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	515,609,082.28	515,085,289.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,282,929,091.03	2,788,530,144.01

2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	658,350,823.00	2,037,585,195.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	309,649,702.00	1,687,259,195.00
120	Нийтлэг татварын бус орлого	306,961,352.00	1,669,839,195.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	306,961,352.00	1,669,839,195.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,635,495.00	7,072,414.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	305,325,857.00	1,662,766,781.00
122	Тусламжийн орлого	2,688,350.00	17,420,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,688,350.00	17,420,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	348,701,121.00	350,326,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,797,221.00	750,000.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	8,797,221.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	339,903,900.00	349,576,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	339,903,900.00	349,576,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	436,320,847.27	515,179,607.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	436,320,847.27	515,179,607.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	432,068,183.50	506,646,315.69
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	228,928,020.87	230,256,928.54
210101	Цалин	191,465,995.00	192,781,238.54
210105	Гэрээтийн цалин	37,462,025.87	37,475,690.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,656,066.22	29,327,192.15
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	19,683,978.30	20,162,349.51
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,243,736.40	2,206,111.95
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,795,149.12	1,836,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	446,907.28	458,999.95
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,486,295.12	4,663,730.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,448,936.41	30,040,994.98
210301	Гэрэл цахилгааны зардал	3,231,756.84	2,913,457.00
210302	Түлш, халаалтын зардал	23,217,179.57	27,127,537.98
2104	Хангамж, бараа материалын зардал	43,846,926.00	28,743,537.58
210401	Бичиг хэргийн материал	9,500,550.00	3,240,230.00

Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахууны зардал	21,873,126.00	19,141,077.58
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,710,000.00	1,470,160.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	200,000.00	-
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	10,563,250.00	4,892,070.00
2105	Нормативт зардал	644,500.00	138,100.00
210502	Хоол	564,500.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	80,000.00	138,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,753,414.00	3,474,273.00
210604	Урсгал засвар	1,753,414.00	3,474,273.00
2107	Томиллот, зочны зардал	4,525,600.00	2,761,000.00
210702	Дотоод томиллотын зардал	4,525,600.00	2,761,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,720,840.00	2,889,988.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	455,400.00	124,800.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	160,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	99,000.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,540.00	161,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64,900.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	627,000.00	951,400.00
210807	Газрын төлбөр	140,000.00	1,309,808.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,543,880.00	179,014,301.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,605,075.00	54,183,385.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	5,642,500.00	416,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,296,305.00	124,414,416.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,252,663.77	8,533,291.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	6,173,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	5,340,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,000,000.00	833,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,252,663.77	2,360,191.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,252,663.77	2,360,191.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	222,029,975.73	1,522,405,587.98
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(0.00)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	222,029,975.73	1,522,405,587.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	353,024,966.00	374,818,414.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,323,845.00	24,492,414.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,635,495.00	7,072,414.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,635,495.00	7,072,414.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,635,495.00	7,072,414.00
122	Тусламжийн орлого	2,688,350.00	17,420,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,688,350.00	17,420,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	348,701,121.00	350,326,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,797,221.00	750,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	750,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчаас	8,797,221.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	339,903,900.00	349,576,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	339,903,900.00	349,576,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	353,024,966.00	374,818,414.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	353,024,966.00	374,818,414.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348,772,302.23	366,285,122.67
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	229,735,295.00	228,615,778.00
210101	Үндсэн цалин	191,465,995.00	191,140,088.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,269,300.00	37,475,690.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,656,066.22	30,968,342.69
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	19,683,978.30	21,803,500.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,243,736.40	2,270,150.95
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,795,149.12	1,836,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	446,907.28	459,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,486,295.12	4,599,691.74
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	26,013,936.41	29,600,994.98
210301	Гэрэл цахилгааны зардал	3,231,756.84	2,913,457.00
210302	Түлш, халаалтын зардал	22,782,179.57	26,687,537.98
2104	Хангамж, бараа материалын зардал	23,282,400.60	22,367,376.00
210401	Бичиг хэрэг	2,899,150.00	2,414,400.00
210402	Тээвэр, шатахуун	16,877,140.60	13,995,076.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,710,000.00	1,587,100.00

Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	166,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,596,110.00	4,204,800.00
2105	Нормативт зардал	80,000.00	66,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	80,000.00	66,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,236,714.00	5,133,093.00
210601	Багаж техник хэрэгсэл	4,000,000.00	-
210604	Урсгал засвар	1,236,714.00	5,133,093.00
2107	Томилолт, зочны зардал	4,525,600.00	2,761,000.00
210702	Дотоод албан томилолт	4,525,600.00	2,761,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,940,840.00	2,741,938.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	455,400.00	250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	99,000.00	56,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	174,540.00	161,530.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	847,000.00	676,200.00
210807	Газрын төлбөр	140,000.00	1,309,808.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,301,450.00	44,030,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,371,450.00	43,613,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,930,000.00	416,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,252,663.77	8,533,291.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	6,173,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	-	5,340,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,000,000.00	833,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,252,663.77	2,360,191.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,252,663.77	2,360,191.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	
2200	Дотоод эх үүсвэрээр	-	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(0.00)	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн				
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,230,472,840.41	515,609,082.28	-480,069,366.66	1,266,012,556.03
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,230,472,840.41	515,609,082.28	-480,069,366.66	1,266,012,556.03
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			523,792.36	523,792.36
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,230,472,840.41	515,609,082.28	-479,545,574.30	1,266,536,348.39
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		-523,792.36		-523,792.36
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			1,522,405,587.98	1,522,405,587.98
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,230,472,840.41	515,085,289.92	1,042,860,013.68	2,788,418,144.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	349,576,400.00	348,132,808.67	1,443,591.33	99,6%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	349,576,400.00	348,132,808.67	1,443,591.33	99,6%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343,403,300.00	341,959,708.67	1,443,591.33	99,6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,511,000.00	228,378,790.00	1,132,210.00	99,5%
210101	Үндсэн цалин	191,241,300.00	190,903,100.00	338,200.00	99,8%
210102	Нэмэгдэл				
210104	Урамшуулал				
210105	Гэрээт ажлын хөлс	38,269,700.00	37,475,690.00	794,010.00	97,9%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,983,900.00	30,968,342.69	15,557.31	99,9%
210201	Тэтгэврийн даатгал	21,803,500.00	21,803,500.00		100%
210202	Тэтгэмжийн даатгал	2,295,100.00	2,270,150.95	24,949.05	98,9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,836,000.00	1,836,000.00		100%
210204	Ажилгүйдлийн даатгал	459,000.00	459,000.00		100%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,590,300.00	4,599,691.74	-9,391.74	100,2%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,187,700.00	29,187,537.98	162.02	100%
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,500,000.00		100%
210302	Түлш, халаалт	26,687,700.00	26,687,537.98	162.02	100%
210303	Цэвэр, бохир ус				
2104	Хангамж, бараа материалын зардал	16,005,400.00	15,985,100.00	20,300.00	99,9%
210401	Бичиг хэрэг	2,414,400.00	2,414,400.00		100%
210402	Тээвэр, шатахуун	10,911,800.00	10,911,800.00		100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,257,800.00	1,237,100.00	20,700.00	98,4%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,245,800.00	1,255,800.00	-1,000.00	100,1%
	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгах	166,600.00	166,000.00	600.00	99,6%
2105	Нормативт зардал	66,600.00	66,600.00		100%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл				
210502	Хоол, хүнс				
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	66,600.00	66,600.00		100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,288,900.00	2,288,900.00		100%
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл				
210604	Урсгал засвар	2,288,900.00	2,288,900.00		100%
2107	Томилот, зочны зардал	2,766,400.00	2,761,000.00	5,400.00	99,8%

Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	2,766,400.00	2,761,000.00	5,400.00	99,8%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,011,900.00	2,741,938.00	269,962.00	91%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	250,000.00		100%
	Аудит ,баталгаажуулалт	403,200.00	288,000.00	115,200.00	71,4%
210803	Даатгалын үйлчилгээ	99,000.00	56,400.00	42,600.00	57%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,500.00	161,530.00	15,970.00	91%
210806	Мэдээллийн технологийн зардал	676,200.00	676,200.00		100%
210807	Газрын төлбөр	1,340,000.00	1,309,808.00	30,192.00	97,7%
	Бараа үйлчилгээний бусад зардал	29,581,500.00	29,581,500.00		100%
	Бараа үйлчилгээний бусад	29,165,000.00	29,165,000.00		100%
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,500.00	416,500.00		100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,173,100.00	6,173,100.00		100%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг				
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,173,100.00	6,173,100.00		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал				
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,340,100.00	5,340,100.00		100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж				
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	833,000.00	833,000.00		100%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	349,576,400.00	349,576,000.00		
31	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
310001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	349,576,400.00	349,576,000.00		
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		24,325,414.00	-24,325,414.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		24,325,414.00	-24,325,414.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		24,325,414.00	-24,325,414.00	
	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал		236,988.00	-236,988.00	
210101	Үндсэн цалин		236,988.00	-236,988.00	
	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал		413,457.00	-413,457.00	
210301	Гэрэл цахилгаан		413,457.00	-413,457.00	
2104	Хангамж, бараа материалын зардал		6,382,276.00	6,382,276.00	-
210403	Шуудан холбоо интернэт		350,000.00	-350,000.00	
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх		2,949,000.00	-2,949,000.00	
210402	Тээвэр, шатахуун		3,083,276.00	-3,083,276.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,844,193.00	-2,844,193.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210604	Урсгал засвар		2,844,193.00	-2,844,193.00	
	Бараа үйлчилгээний бусад		14,448,500.00	-14,448,500.00	
210901	Бараа үйлчилгээний бусад		14,448,500.00	-14,448,500.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
2132	Бусад урсгал шилжүүлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал				
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		25,242,414.00	-25,242,414.00	
31	Нэмэлт санхүүжилтийн орлого				
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		750,000.00	-750,000.00	
131104	Хандив тусламж /дотоод		17,420,000.00	-17,420,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		7,072,414.00	-7,072,414.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Давст сумын Засаг даргын тамгын газар нь Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ, мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давст сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 436,320.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,343.2 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 515,179.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 5,151.8 мянган төгрөгийн 80 хувиар тооцож 4,121.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Давст сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,505,601.0 мянган төгрөгөөр буюу 117.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	44,110.0	24,080.0	-20,030.0
Урьдчилгаа			
Бараа материал	46,834.0	76,018.3	29,184.3
Үндсэн хөрөнгө	1,191,985.1	2,688,431.8	1,496,446.7
Нийт хөрөнгө	1,282,929.1	2,788,530.1	1,505,601.0
Өр төлбөр	16,916.5	112.0	-16,804.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,266,012.5	2,788,418.1	1,522,405.6

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,282,929.1	2,788,530.1	1,505,601.0
---	-------------	-------------	-------------

Авлага дансны үлдэгдэл 24,080.0 мянган төгрөг болж 20,030.0 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгөөр барагдсан авлагаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 76,018.3 мянган төгрөг болж 29,184.3 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хандивын бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэсэн нь 2022 оны ковид-19 цар тахалд зарцуулагдахаар байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,688,431.8 мянган төгрөг болж 1,496,446.7 мянган төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд урсгал төсвийн худалдан авалтаар 10,649.9 мянга, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,556,996.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс акталж устгасан 1,349,063.2 мянган төгрөг хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 112.0 мянган төгрөг болж 16,804.5 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өр төлбөрийг барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,788,418.1 мянган төгрөг болж 1,522,405.6 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн хөрөнгөтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,379,234.4 мянган төгрөгөөр буюу 209 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орлого өсөхөд үнэ төлбөргүй хүлээж авсан орлого нөлөөлсөн байна. Энэ нь хөрөнгө оруулалттай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 78,858.7 мянган төгрөгөөр буюу 18 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс зардал өсөхөд бараа үйлчилгээний бусад зардал голчлон нөлөөлсөн байна. Энэ нь ковид-19 цар тахлын хандивтай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 329,235.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 329,235.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 20,341.4 мянган төгрөгөөр бууруулж 349,576.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 349,576.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 349,576.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 349,576.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 348,132.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үндсэн санхүүжилтийн данснаас 1,443.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 348,132.8 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас 750.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,072.4 мянга, хандив тусламж, дотоод 17,420.0 мянга, нийт 25,242.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс гэрэл цахилгааны зардалд 413.4 мянга, цалингийн зардалд 236.9 мянга, тээвэр шатахууны зардалд 3,083.3 мянга, шуудан холбоо, интернэтийн зардалд 350.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 14,448.5 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 2,949.0 мянга, урсгал засварт 2,844.2 мянга, нийт 24,325.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 917.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал байхгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Давст сумын Засаг даргын тамгын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 151 байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,464,119.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нягтлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасныг зөрчин тооцоо үүсгэхгүйгээр 2,069.9 мянган төгрөгийн гүйлгээг шууд зардалд бүртгэсэн байна.
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дэх хэсэгт “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчин Торхилгийн голын гүүр 1,444,049.8 мянга, Зүүн сайгийн гүүр 18,000.0 мянга, нийт 1,462,049.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Давст сумын Засаг даргын тамгын газар	2	1,464,119.8	2	1,464,119.8						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

2022 оны 02 сарын 24-ний өдөр